



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/389

Булган сум

“Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, нийлүүлэх ажил зохион байгуулах тухай”

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.3 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2022 оны 36 дугаар “Хүнсний хангамж, аюулгүй байдлын талаар авах арга хэмжээний тухай” тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн А/137 дугаар “Бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, нийлүүлэх хуваарь батлах тухай” тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Төрийн өмчийн цөм сүрэг бүрдүүлэх зорилгоор баталгаажсан үүлдэр, омгийн малын стандартын шаардлага хангасан бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлэх, нийлүүлэх ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн технологийн хугацаанд үр дүнтэй зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т даалгасугай.

2.Дээрх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлж, хамтран ажиллахыг холбогдох сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ